

ТАНИЛЦУУЛГА

Нэг. Иргэд, байгууллагаас цагдаагийн байгууллага, албан тушаалтанд гаргасан санал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар

Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн албан тушаалтанд 2016 оны 1 дүгээр улиралд иргэд, байгууллагаас 2502 санал, өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 121 нэгж буюу 5.1 хувиар өсчээ.


Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 72 буюу 2.9 хувь нь санал, 2372 буюу 94.8 хувь нь

Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдол



өргөдөл, 58 буюу 2.3 хувь нь гомдол байна.

Санал, өргөдөл, гомдлыг үтгээр нь авч үзвэл: 360 буюу 14.4 хувь нь ажилд орох, суралцахыг хүссэн, 104 буюу 4.2 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 319 буюу 12.7 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 540 буюу 21.6 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 86 буюу 3.4 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 1093 буюу 43.7 хувь нь бусад өргөдөл гомдол байна.



Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 2444 буюу 97.7 хувийг шийдвэрлэж, 58 буюу 2.3 хувь нь ажиллагаанд байна.


Хоёр. Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн талаар

2016 оны 1 дүгээр улиралд Цагдаагийн ерөнхий газрын удирдлагуудад иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 165 өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36 нэгж буюу 17.9 хувиар буурчээ.

Нийт хүлээн авсан өргөдөл, гомдлын 1 буюу 0.6 хувь нь санал, 9 буюу 5.5 хувь нь гомдол, 155 буюу 93.9 хувь нь өргөдөл байна.





Иргэд, байгууллагаас цагдаагийн албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл, гомдлыг үтгээр нь авч үзвэл: 12 буюу 7.3 хувь нь ажилд орох суралцахыг хүссэн, 17 буюу 10.3 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 24 буюу 14.6 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 7 буюу 4.2 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 20 буюу 12.1 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 85 буюу 51.5 хувь нь бусад өргөдөл, гомдол байна.



Гурав. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 11-11 төвд ирсэн өргөдөл, гомдол, шүүмжлэл, санал хүсэлтийн талаар

2016 оны 1 дүгээр улиралд иргэдээс Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын “11-11” төвд цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 188 санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдөл ирүүлсний 60 буюу 31.9 хувь нь санал хүсэлт, 72 буюу 38.3 хувь нь гомдол, 45 буюу 24.0 хувь нь талархал, 10 буюу 5.3 хувь нь шүүмжлэл, 1 буюу 0.5 хувь нь өргөдөл байна.



Иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдлийн 149 буюу 79.3 хувийг шийдвэрлэж, 39 буюу 21 хувь нь ажиллагаанд байна.

Иргэдэд хариу хүргүүлсэн байдлыг чанараар нь авч үзвэл 59 буюу 31.4 хувийг 5 хоногийн дотор, 129 буюу 68.6 хувийг 5-аас дээш хоногт шийдвэрлэжээ.

Дөрөв. Иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдлын талаар

2016 оны 1 дүгээр улиралд иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой 389 өргөдөл, гомдол хүлээн авч шалгасныг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11 нэгж буюу 2.8 хувиар буурч, 402 алба хаагч холбогдсоны 322 буюу 80.1 хувь нь офицер, 76 буюу 18.9 хувь нь ахлагч, 4 буюу 1.0 хувь нь энгийн ажилтан байна. Нийт өргөдөл гомдлын 291 буюу 74.8 хувийг барагдуулж, 98 буюу 25.2 хувь нь ажиллагаанд байна.

